

ТӨМӨР ЗАМЫН ГАЗРЫН 2025 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2025 оны 09 дүгээр сарын 25

Төмөр замын бүтээн байгуулалтын ажлын чиглэлээр:

Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан 19.5 км төмөр замын бүтээн байгуулалтын бэлтгэл ажил 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн байдлаар 60%-тай үргэлжилж байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК, БНХАУ-ын “Төмөр замын барилгын гүүрийн инженерийн товчоо групп” ХХК нар санхүүжилтийн гурван талт гэрээг байгуулж, 09 дүгээр сарын 01-ний өдөр урьдчилгаа 30% төлбөрийг шилжүүлсэн. Хилийн өргөст торон хашаа 12.5 км 100%, гаалийн хяналтын байр, хяналтын авто пүү, бетон зам 100%, бетон зуурмагийн үйлдвэрийн угсралтын ажил 37.5%, арматур бэлтгэх талбайн ажил 53.3%, дайрга хадгалах агуулах 19.4%, ажилчдын кемп байгуулах ажил 41.6%-тай үргэлжилж байна. Төслийн талбайд 18 инженер, 118 ажилчин, нийт 35 машин механизм ажиллаж байна. Хил дамнасан гүүрийн барилга угсралтын ажил хилийн зурвас дахь 114 ширхэг шон суурийг өрөмдөж, үргэлжлүүлэн нутгийн гүн рүү 2382 шон суурь өрөмдөх ёстой ч “Бүтээн байгуулалтын хаалттай бүс”-д мөрдөх түр журам батлагдаагүйн улмаас өрөмдлөгийн ажил зогссон. Хилийн зурвас дахь хоёр улсын хамтран барих В176 дугаар тулгуур шонгийн дээд хөндлөн нурууны /ригель/ арматурчлалын ажил хийгдэж байна.

Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн салбар төмөр зам барих төслийн далан байгуулах ажлын тоо хэмжээ-6.85 сая.м³ гүйцэтгэхээс 6.26 сая.м³ буюу 91.06%-ийг гүйцэтгэсэн, ухмал байгуулах ажлын тоо хэмжээ-8.60 сая.м³ гүйцэтгэхээс 98.72% буюу 8.20сая.м³-ийг гүйцэтгэсэн, төмөр бетон дугуй хоолойн ажил 61 байршилд барихаас өнөөдрийн байдлаар гүйцэтгэл-72.62%, гүүрийн ажил 5 байршилд, 652 урт метр, гүйцэтгэл-76%, гүйцэтгэгч 10 компани, төмөр бетон дөрвөлжин хоолойн ажил 22 ширхэг, гүйцэтгэл 48.59%, гүйцэтгэгч 15 компани, дээд бүтцийн барилга угсралтын ажил ПК0+000-ПК5+425 цэгийн хооронд угсралт, ПК0+000-ПК7+000 цэгийн хооронд бетон дэрийг замын трассын дагуу зулах ажил тус тус хийгдсэн. “Улаабаатар бүк” ХХК-иас эхний ээлжид 12880 ширхэг дэр бетон авахаас 128880 ширхэг дэр бетон хүлээн авч Багахангай-Хөшигийн хөндийн чиглэлийн төмөр замын төслийн талбай руу ачилт хийгдсэн. Төслийн ажилд дотоодын 63 аж ахуйн нэгж, байгууллагын 2748 инженер техникийн ажилтан 1453 техник, тоног төхөөрөмжтэй ажиллаж байна.

Төмөр замын тээврийн ачааг нэмэгдүүлэх чиглэлээр:

Төмөр замын тээврээр 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр нийт 28,12 сая.тн ачаа, 1,2 сая зорчигч тээвэрлээд байна. Монгол Улсын Замын-Үүд, БНХАУ-ын Эрээн төмөр замын боомтоор хоногт дунджаар өргөн царигийн төмөр замаар 16, нарийн царигийн төмөр замаар 7,5 галт тэрэг, Монгол Улсын Сүхбаатар, ОХУ-ын Наушки төмөр замын боомтоор 7,9 галт тэрэг солилцож “Улаанбаатар төмөр зам” ХНН 22,8 сая.тн ачаа, “Монголын төмөр зам” ТӨХК 4,1 сая.тн ачаа, “Монголиантранс лайн” ХХК 1,22 сая.тн ачаа, “Улаанбаатар төмөр зам”

ХНН олон улсын 32.20 мян.хүн, орон нутгийн 1,183.19 мян.хүн, “Монголын төмөр зам” ТӨХК 1.06 мян.хүн, “Тавантолгой төмөр зам” ХХК 1.93 мян.хүн, нийт 1,2 сая зорчигч тээвэрлээд байна.

“Монголын төмөр зам” ТӨХК, БНХАУ-ын “Чайна Энержи Коксжих нүүрс /Тяньжин/” ХХК-тай байгуулсан “Нүүрс тээвэрлэлтийн урт хугацааны хамтын ажиллагааны гэрээ”-ний дагуу 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 1,5 сая.тн нүүрс төмөр замаар тээвэрлэж, 1,3 сая.тн нүүрс хилээр гаргаад байна.

Төмөр замын суурь бүтэц, салбар замд техникийн нөхцөл олгох чиглэлээр:

“Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Сайншанд, Улаанбаатар-2 өртөөний зам болон “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Хулангийн шанд зөрлөгийн замд дохиолол холбооны хяналтын тоног төхөөрөмж байрлуулах ажлыг судлан 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 25/44/49, 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 25/44/50, 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 25/44/51 дугаартай техникийн нөхцөлийн дүгнэлт гаргав.

Зам, тээврийн яамны дэргэдэх Төмөр зам, далайн тээврийн салбарын шинжлэх ухаан, технологийн дэд зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн хурлаар “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн боловсруулсан “Ачааны вагоны үйлдвэр”-ийн ТЭЗУС болон “Эссенз саплайз” ХХК-ийн боловсруулсан Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын төслийн ТЭЗҮ-ийн төслийг хэлэлцэж, 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 01/315, 01/316 дугаартай албан бичгээр тус байгууллагад санал зөвлөмжийг хүргүүлэв.

Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбогдолтой объект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлэх чиглэлээр:

Төмөр замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.16-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж Төмөр замын газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар 12 хуулийн этгээдийн төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой дагнасан хэрэглээний зам, талбайн 5 объект, 827 хөдлөх бүрэлдэхүүнийг гэрчилгээжүүлж, 9 хуулийн хуулийн этгээдэд төмөр замын тээвэр зуучлалын, дагнасан хэрэглээний зам, талбай барих, дагнасан хэрэглээний замын дээд, доод бүтцийн засвар, арчлалт гүйцэтгэх үйл ажиллагааны гэрчилгээг олгов.

Хөдлөх бүрэлдэхүүний чиглэлээр:

“Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт. “Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтад тавих шаардлага” MNS 6630-3:2024 стандартын дагуу “Монголиан транс ложистик” ХХК-ийн эзэмшлийн ТЭМ-7385, ТЭМ-0753 илчит тэргэнд 923122273850, 923122207536 дугаарыг олгов.

Суурь бүтцүүдийн техникийн хүчин чадал, багтаамжийг хөдлөх бүрэлдэхүүний хэмжээтэй уялдуулах, вагон эргэлтийн хугацааг багасгах, ачаа тээврийн үйлчилгээг шуурхай зохион байгуулах үүднээс “УБТЗ” ХНН-ийн суурь бүтцээс бусад суурь бүтэц дээр тээвэрлэлт хийхээр хилээр орж ирсэн ачааны вагоныг суурь бүтцээс гаргах арга хэмжээг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд зохион байгуулж

ажиллахыг “УБТЗ” ХНН-т 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 01/320 дугаарын албан бичгээр мэдэгдлээ.

Хөдлөх бүрэлдэхүүнд шинээр дугаар, код олгосон, мэдээллийн санд бүртгэсэн болон Монгол Улсад ашиглагдаж байгаа төрийн болон хувийн эзэмшлийн, түрээсийн гадаад хөдлөх бүрэлдэхүүний паркийн тоо, төрлийн тайлан мэдээллийг Зам, тээврийн яаманд 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 06/348 дугаартай албан бичгээр танилцуулсан.

Хяналт шалгалтын ажлын чиглэлээр:

Төмөр замын тээврийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан чиг үүргийн хүрээнд Төмөр замын газрын даргын 2025 оны А/34 дүгээр тушаалаар баталсан хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд “УБТЗ” ХНН-ээр үйлчлүүлдэг “Багануур” ХК, “Шивээ Овоо” ХК, “Шарын гол” ХК, “Амгалан ДЦС” ТӨХК, “ДЦС 4” ТӨХК, “ДЦС 3” ТӨХК, “ДЦС 3” ТӨХК, “Дарханы ДЦС” ТӨХК, “Эрдэнэтийн ДЦС” ТӨХК-ийн түлш дамжуулах цех, төмөр замын хэсгийн өвөлжилтийн бэлтгэл ажлын хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудад Улсын байцаагчийн 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 04-13-03/142/01, 04-13-03/142/02, 04-13-03/142/03, 04-13-03/142/04, 04-13-03/142/05, 04-13-03/142/06, 04-13-03/142/07, 04-13-03/142/08, 04-13-03/142/09 дугаартай албан шаардлага, актыг хүргүүлсэн.

Улсын ерөнхий байцаагчийн баталсан 25/04-13-03/141/03 дугаартай удирдамжийн дагуу “УБТЗ” ХНН-ийн Дохиолол холбооны 2 дугаар ангийн объект, засвар үйлчилгээ хийх үйл ажиллагаанд 2025 оны 09 дүгээр сарын 09-12-ны өдөр төлөвлөгөөт хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах тухай Улсын байцаагчийн 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 04-13-03/141/10 дугаартай албан шаардлагыг хүргүүллээ.

Төмөр замын тээврийн салбарт гарсан 6 зөрчлийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шалган шийдвэрлэсэн бөгөөд 2 хэрэг дээр ажиллагаа явагдаж байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон Зам, тээврийн сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын 2025 оны 3 дугаар улирлын тайлан биелэлтийг Зам, тээврийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт 2025 оны 09 дүгээр сарын 11, 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр тус тус цахимаар тайлагнав.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх зам, тээврийн салбарын төлөвлөгөөний биелэлтийн тайланг Зам, тээврийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр, Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газарт 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр цахимаар, Бодлого, төлөвлөлтийн газарт 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 02/321 дугаартай албан бичгээр тайлагнав.

Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А/225 дугаар тушаалын

хавсралтаар баталсан Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн “Нийгэмд шударга ёсыг бэхжүүлж, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 64 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг Зам, тээврийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 02/312 дугаарын албан бичгээр танилцууллаа.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг Зам, тээврийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 02/347 дугаартай албан бичгээр танилцуулсан.

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр:

Гадаад уулзалт: Төмөр замын газрын удирдлага ОХУ-ын Холбооны төмөр замын тээврийн агентлаг (Росжелдор)-ын дарга Сахаров Александр Геннадьевичтэй 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр цахим уулзалт хийсэн. Талууд уулзалтаар өөр өөрийн байгууллагын үйл ажиллагааг танилцуулж, ойрын хугацаанд биечлэн уулзаж, хоёр улсын төмөр замын зорчигч, ачаа тээврийн харилцааг бэхжүүлэх, төмөр замын үйлдвэрлэл, суурь бүтцийг хөгжүүлэх, хүний нөөцийг бэлтгэх чиглэлээр дэлгэрэнгүй ярилцахаар тохиролцсон.

Уулзалтын мөрөөр “Монгол Улсын Төмөр замын газар, ОХУ-ын Холбооны төмөр замын тээврийн газар хоорондын Харилцан ойлголцлын санамж бичгийн төсөл”-ийг бэлтгэж, хэлэлцэх асуудлын саналын хамт чиглэл авахаар Зам, тээврийн яаманд 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 01/356 дугаар албан бичгийг хүргүүлээд байна.

Гадаад томилолт: Зам, тээврийн сайдын 2025 оны А/226 дугаар тушаал, Төмөр замын газрын даргын А/42 дугаар тушаалын дагуу Төмөр замын газрын дарга Б.Артур, тус газрын Эрдэм шинжилгээ, техник технологи, судалгааны газрын дарга Л.Булганхүү, Суурь бүтцийн газрын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Нарантунгалаг нар 2025 оны 09 дүгээр сарын 15-19-ний өдөр БНСУ-д албан томилолтоор ажиллав.

Томилолтоор ажиллах хугацаанд БНСУ-ын Газар, дэд бүтэц, тээврийн яамнаас зохион байгуулсан “Дэлхийн дэд бүтцийн хамтын ажиллагааны бага хурал”-д оролцов. Түүнчлэн БНСУ-ын Дэжон хотноо байрлах “Солонгосын үндэсний төмөр зам” байгууллага /KNR/-д зочлон, тус байгууллагын гүйцэтгэх захирал Ли Сон Хэтэй уулзаж, хоёр улсын төмөр замын салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх тухай Хамтын ажиллагааны санамж бичгийг байгууллаа.

Үүнээс гадна, тус газрын дарга Б.Артур Зам, тээврийн сайдыг дагалдан 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс 9 дүгээр сарын 05-ны өдрүүдэд БНХАУ, ОХУ-д тус тус ажиллав.

Гадаад зочин төлөөлөгч: Төмөр замын газрын урилгаар БНХАУ-ын “Хятадын төмөр замын дохиолол холбооны корпораци” ХХК-ийн ТУЗ-ийн дарга Лоу Чилиан тэргүүтэй төлөөлөгчид 2025 оны 09 дүгээр сарын 09-12-ны өдрүүдэд Монгол Улсад

айлчилж, Монгол, Хятадын төмөр замын дохиолол холбооны салбарын мэргэжилтнүүдийн зөвлөлдөх уулзалтыг хамтран зохион байгуулав.

Талууд уулзалт, хэлэлцээний мөрөөр цаашид төмөр замын дохиолол холбооны салбарын норм стандартын чиглэлээр харилцан туршлага, мэдээлэл солилцох, Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн салбар төмөр замын төслийн хүрээнд байгуулагдах терминалд ухаалаг дохиолол холбоо, хяналт удирдлагын системийг нэвтрүүлэх, Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр зам дагуу хийх эргүүлийг хяналтын дроны технологиор оруулах туршилтыг хамтран хийж гүйцэтгэхээр тохиролцсон. Эдгээр ажлуудын хэрэгжилтийг хариуцах ажлыг хэсгийг Төмөр замын газар, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн төлөөллүүдийг хамруулан байгуулахаар ажиллаж байна.

Төсөл, арга хэмжээ: БНХАУ-ын Улсын төмөр замын газрын 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн “Замын-Үүд-Эрээн боомтын 1435 мм царигтай 2 дахь замыг хамтран барих тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төсөлд дахин санал авах тухай албан бичгийн хариуг төлөвлөж, хэлэлцээрийн төсөлд тусгах саналаа бэлтгэн Хятадын талд 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 01/324 дүгээр албан бичгээр хүргүүлэв.

Хятадын талаас Замын-Үүд-Эрээн боомтын нарийн царигийн 2 дахь замыг холбох, Ханги-Мандалын ачаа тээврийн хэмжээг нэмэгдүүлэх, Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын явцтай танилцах зорилгоор 2025 оны 10 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд Эрээн, Мандал, Ганцмод боомтуудад холбогдох төлөөллүүдийг томилон ажиллуулахаар төлөвлөж байгаа бөгөөд тус томилолтын дараа цахим хурал товлон хуралдах саналтай байгаагаа илэрхийлсэн.

Замын-Үүд өртөөний нарийн царигийн паркийн өргөтгөл, дагалдан байгуулах терминалын хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж, хамтран ажиллах асуудлаар БНХАУ-ын “Хөх хотын төмөр замын гадаад эдийн засаг, технологийн хамтын ажиллагааны групп” ХХК-тай байгуулсан уулзалтын протоколын дагуу шаардлагатай арга хэмжээг авч ажиллах Ажлын хэсгийг Төмөр замын газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр хуралдаж, Хятадын талд төслийн зураг төсөл, ТЭЗҮ боловсруулахад шаардлагдах мэдээлэл, материалыг зураг төсөл боловсруулах ажлын даалгаврын хамт хүргүүлэхээр ажиллаж байна.

___o0o___